



## ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/214

Улаанбаатар хот

### Өндөр эрсдэлт эмийн хэрэглээг хянах, зохицуулах журам батлах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, 20.2.2, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.7.2, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1, Монгол улсын стандарт “Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2015”-ын 10.1, 11.1, 12.1, “Эм эмнэлгийн хэрэгсэлийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага MNS 5530:2014”-ийн 7.1, 8.1, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 09 дүгээр сарын 07- ны өдрийн А/414 дүээр тушаал “Эмийн эмчилгээний зохицуулах хорооны ажиллах журам”, Олон улсын магадлан итгэмжлэлийн стандартын 3 дугаар бүлгийн 3 дахь хэсэг, Эмнэлгийн дүрмийн 5 дугаар зүйл 5.1.1, 5.1.7, Хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйл 8.1.3 –т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөр эрсдэлт эмийн хэрэглээг хянах, зохицуулах журмыг нэгдүгээр, Өндөр эрсдэлт эмийн жагсаалтыг хоёрдугаар, Ижил дуудагддаг, ижил харагддаг эмийн жагсаалтыг гуравдугаар, Өндөр эрсдэлт эмийн гарч болзошгүй эрсдэл, авах арга хэмжээг дөрөвдүгээр, Өндөр эрсдэлт эмийн хяналтын хуудсыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Энэхүү тушаалын хэрэгжүүлэхэд арга зүйгаар хангаж удирдан зохион байгуулж ажиллахыг Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал (хурандаа Т.Нарантуяа), хавсралтаар баталсан журмыг мөрдөж ажиллахыг Эм зүйн алба (ахмад Д.Төмөрхүү)-д тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын алба (ахмад Ч.Өнөрсайхан), Дотоод аудитор (Ц.Болормаа) нарт тус тус даалгасугай.

2022002110

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан эмнэлгийн захирлын 2020 оны А/38 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЗАХИРАЛ,  
ДЭД ХУРАНДАА



Х.БАТ-ИРЭЭДҮЙ

Эмнэлгийн захирлын 2022 оны  
11 дугаар сарын 20-ны өдрийн А/214  
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



## ӨНДӨР ЭРСДЭЛТ ЭМИЙН ХЭРЭГЛЭЭГ ХЯНАХ, ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Зорилго

1.1. Амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх тасагт үйлчлүүлэгчдэд өндөр эрсдэлт эмийн жор бичих, эмчилгээнд хэрэглэх, эмчилгээний хяналт хийх болон эмээс шалтгаалах эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг зохицуулж, эмийн аюулгүй байдлыг сайжруулахад оршино.

### Хоёр. Хамрах хүрээ

2.1. Эмнэлгийн эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтнууд хамрагдана. Өндөр эрсдэлт эмийг дараах тасаг, хэсэгт байршуулан хэрэглэнэ. Үүнд:

- Эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэг хагалгааны тасаг
- Яаралтай тусламжийн тасаг
- Эмчилгээний тасгууд
- Гемодиализийн хэсэг
- Дүрс оношилогооны хэсэгт
- Амилуулах суурь тусламжийн цүнх

### Гурав. Нийтлэг зүйл

3.1. Нэр томъёоны тайлбар

3.1.1. “Өндөр эрсдэлт эм” гэж эмийн эмчилгээний алдаа үүссэн тохиолдолд эмчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд сөрөг үр дагавар үзүүлэх буюу эмийн гаж нөлөө үүсгэх эрсдэл өндөртэй эмийг хэлнэ.

3.1.2. “Ижил харагддаг эм” гэж эмийн анхдагч болон хоёрдогч савлагааны харагдах байдал адил эмийг хэлнэ

3.1.3. “Ижил дуудагддаг эм” гэж эмийн олон улсын ба худалдааны нэршил төстэй учраас андуурагдах эрсдэлтэй эмийг хэлэх бөгөөд өндөр эрсдэлт эмэнд хамруулж үзнэ.

3.2. Өндөр эрсдэлт эмийн жагсаалтыг Эмнэлгийн эмийн эмчилгээг зохицуулах хорооны хурлаар хэлэлцэн баталж, эмнэлгийн эмийн жагсаалтад өөрчлөлт оруулах үед хамтад нь шинэчилнэ. Өндөр эрсдэлт эмийн бүлэгт дараах бүлгийг хамруулна.

Үүнд:

- Антикоагулянт
- Инсулин

- Өндөр концентрацтай электролит уусмал
- Мансууруулах сэтгэц нөлөөт эм
- Судас идэвхт эм
- Мэдрэл булчингийн хориглогч эмүүд
- Хими заслын эмүүд
- Ижил харагддаг болон Ижил дуудагддаг эмүүд

### **Дөрөв. Өндөр эрсдэлт эмийн захиалга бэлтгэх, олгох, хадгалах**

Эм зүйн албанд өндөр эрсдэлт эмийн жор бэлтгэх үйл явцад дараах зарчмыг мөрдөж ажиллана. Үүнд:

4.1. Өндөр эрсдэлт эмийг захиалгын дагуу эм олгох үйл ажиллагааг “Хэвтэн эмчлүүлэх тасагт нэгж тунгаар, эм олгох үйл ажиллагааны журмын дагуу, давхар хяналтын зарчим мөрдөж ажиллана.

4.2. Эмийн захиалгад “Ижил дуудагдах эм”-ийн нэрсийн ижил дуудагддаг, харагддаг үеийг **ТОМ** үсгээр бичнэ.

4.3. Өндөр эрсдэлт, ижил дуудагддаг, ижил харагддаг эмүүдэд утсаар болон аман захиалга хийхгүй байна. Зайлшгүй шаардлагатай үед аман захиалгыг утсаар (аман захиалга өгөх журмын дагуу) өгч болох боловч хими эмчилгээний эм тарианд хамаарахгүй

4.4. Өндөр эрсдэлт эмийн жорыг нэгж тунгийн зарчмаар бэлтгэж, нэг дор олон хоногийн тунг олгохгүй.

4.5. Өндөр эрсдэлт эмийг нэгж тунгийн системээр олгож савлаж олгохдоо **“Улаан өнгө”** бүхий ӨНДӨР ЭРСДЭЛТ ЭМ, HIGH ALERT тусгай анхааруулга бүхий ялгах тэмдэг, ижил харагдах, ижил дуудагдах эмэнд **“Улбар шаргал”** өнгийн “Өндөр эрсдэлт эм”, “look alike sound alike” гэсэн ялгах тэмдэг нааж олгоно.

4.6. Тасаг, нэгжид байрлах эмийн хадгалах шүүгээ, тавиурт “Өндөр эрсдэлт эм”, “Ижил харагдах ижил дуудагдах эм” гэсэн ялгах тэмдэг байршуулсан байна.

4.7. “Ижил харагдах эм”-ийг зургаар баталгаажуулан тасаг нэгжид байршуулан улбар шар өнгийн өндөр эрсдэлт эмийн анхааруулга наасан байна.

4.8. Өндөр эрсдэлт эмийг хадгалах шүүгээнд хадгалж буй эмийн жагсаалт, тоо хэмжээ, хяналтын хуудсыг байршуулж, шүүгээний орлого, зарлагыг ээлжийн сувилагч хянанана.

4.9. Эмийн захиалга, түгээлт, хүлээн авалт зэрэгт эм зүйч болон эмч, сувилагч нар байнга ДАВХАР шалгах үйлдлийг хийнэ.

4.10. Эмийн хэрэглэх арга, гаж нөлөөний заалтыг тодруулж, эмийн нэрийг давтан уншиж, үсэглэн хэлж, заалтыг дурьдана.

4.11. Зориулалтын хаяг тэмдэглэгээтэй саванд бусад эмнүүдээс ялгаж тээвэрлэнэ.

4.12. Өндөр эрсдэлт эмийн жагсаалтад хадгалалтын тусгай горим шаардлагатай болон эмийн нөөцтэй тасаг нэгж, тэргэнцэрийн байршлыг тэмдэглэсэн байна.

4.13. Эмийн бодисыг тасаг нэгжид хадгалахдаа анхааруулга тэмдэг бүхий цаасан тэмдэглэгээтэй хэсэгт бусад эмнээс ялган өөр хооронд нь ижил биш зайнд байршуулна.

4.14. Өндөр эрсдэлт эмүүдийг үйлчлүүлэгчийн дэргэд байлгахыг хориглоно.

#### **Тав. Өндөр эрсдэлт эмийг хэрэглэх.**

5.1. Хэрэглэхийн өмнө тухайн эм өндөр эрсдэлтэй болон ижил харагддаг, ижил дуудагддаг эмийн жагсаалтанд байдаг эсэхийг байнга санаж, эмийг хэрэглэх үедээ анхаарал болгоомжтой байх.

5.2. Эмийн жорыг "MNS5376:2016"-ын дагуу бичиж, жор болон захиалгын хуудсан дээр эмийн тун хэмжээ, хугацаа, хэрэглэх арга байдал зэргийг бүрэн оруулсан байхаас гадна тухайн эмэн дээр ялгах тэмдэг тэмдэглэгээ тавигдсан эсэхийг анхаарах.

5.3. Үйлчлүүлэгч өндөр эрсдэлт эмийг эмчилгээнд хэрэглэх үед сувилагч хяналт тавьж ажиллах ба шаардлагатай тохиолдолд эмчийн хяналтад хийнэ.

5.4. Судсаар хэрэглэх эмийг зориулалтын тариур болон системээр хийж, шахуургын тохиргоо, тарилгын хурд зэргийг хянан, аюулгүй ажиллагааг мөрдөнө.

5.5. Судсаар хэрэглэх өндөр эрсдэлт эмийг шингэлсэн дуслын шингэний уут, савлагаа дээр өндөр эрсдэлт эмийн анхааруулга нааж, эмийг хэрэглэж эхэлсэн огноо, цагийг тэмдэглэж, эмийн ампулыг нааж бэхэлнэ.

5.6. Эм хэрэглэсэн арга, огноо, цаг, эмчилгээний хяналтын (шинжилгээ, амин үзүүлэлт г.м) үзүүлэлтүүд болон эмийг хэрэглэх үед илэрсэн сөрөг нөлөө, авсан арга хэмжээний тухай болон бусад тэмдэглэлийг өвчний түүхэнд тэмдэглэнэ.

#### **Зургаа. Эрсдэлээс сэргийлэх үйл ажиллагаа**

6.1. Эмнэлгийн эм зүйч хариуцсан тасаг нэгжийн өндөр эрсдэлт эмийн хэрэглээ, орлого, зарлага болон хадгалалтыг хянана.

6.2. Өндөр эрсдэлт эмийн хугацааны хяналт, хадгалалт, хамгаалалтыг тухайн тасгийн ахлах сувилагч, ээлжийн сувилагч хариуцах бөгөөд хяналтыг эмнэлзүйн эм зүйч хийж, хугацаа дууссан, чанар байдал өөрчлөгдсөн тохиолдолд эм зүйн албанд эм бараа буцаан татах устгах зааврын дагуу эм зүйн албанд буцаана.

6.3. Эмнэлгийн өндөр эрсдэлт эмийн хэрэглээний хяналт, судалгааны тайланг эм зүйн албаны дарга “Эмийн эмчилгээг зохицуулах хороо”-нд жил бүр тайлагнаж, эмнэлгийн нийт мэргэжилтнүүдэд мэдээлнэ.

6.4. Эм зүйн алба эмнэлэгт хэрэглэх өндөр эрсдэлт эмийн талаар эмнэлгийн мэргэжилтнүүдэд мэдээлэл, сургалт зохион байгуулах, эрсдэлээс сэргийлэх ажлыг зохион байгуулна.

6.5. Үйлчлүүлэгчдэд андуурагдах эрсдэлтэй эмнүүдийн талаар анхааруулга санамж байнга өгч, тухайн эм нь танил бус, бодож байснаас нь өөр харагдах юмуу, сонсогдож байгаа тохиолдолд асуулт асуух, шаардлага тавих, лавлагаа авах эрхээр хангах боломжийг бүрдүүлнэ.

6.6. Шинээр бий болж байгаа эмийн хэрэглээний талаарх удирдамж, гарын авлага, заавар, зөвлөмж зэргийн талаарх мэдлэгийг үйлчлүүлэгч нарт тогтмол өгч ажиллана.

#### **Долоо . Хянах, зохицуулах үйл ажиллагаа**

7.1. Өндөр эрсдэлт эмийн хэрэглэх үед эмийн гаж нөлөө илэрсэн бол сувилагч, эмчлэгч болон жижүүрийн эмчид яаралтай мэдэгдэн, эмчилгээний арга хэмжээг авсаны дараа “Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх, зохицуулах журам”-ын дагуу арга хэмжээг авна.


7.2 Өндөр эрсдэлт эмийн хэрэглээтэй холбоотой эмчилгээний алдаа, алдаанд ойрхон тохиолдол илэрсэн үед “Эмийн эмчилгээний алдааг бүртгэн мэдээлэх, зохицуулах журам”-ын дагуу хариу арга хэмжээ авна.

7.3 Өндөр эрсдэлт эмийн алдааны тохиолдлыг илрүүлсэн эмнэлгийн мэргэжилтэн “Тохиолдол мэдээлэх хуудас”-ыг бүрэн бөглөж, тухайн тасгийн чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэнд мэдэгдэнэ.

7.4 Өндөр эрсдэлт эмийн хэрэглээтэй холбоотой эмчилгээний алдаа, алдаанд ойрхон тохиолдлыг эмнэлгийн “Тохиолдол бүртгэн мэдээлэх, авах арга хэмжээг зохицуулах журам ” дагуу авч хэрэгжүүлнэ.



Эмнэлгийн захирлын 2022 оны // дугаар сарын // -ны өдрийн // дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



### ӨНДӨР ЭРСДЭЛТ ЭМИЙН ЖАГСААЛТ

Өндөр эрсдэлт эмийн бүлэг	Өндөр эрсдэлт эмийн нэр	Эмийн тун хэмжээ	Эмийн хэлбэр	
Адренорецептор сэргээх эмүүд	Норэпинефрин	2мг /1мл	туншил	
	Допамин	40мг/мл-5мл	туншил	
	Добутамин	50мг/5мл	туншил	
	Эпинефрин	1мг/1мл	туншил	
	Эфедрин гидрохлорид	30мг/мл-1мл	туншил	
Сэтгэц засах тайвшруулах эм	Диазепам	5мг/мл-2мл	туншил	
	Диазепам	5 мг	шахмал	
	Алпразолам	0.25мг	шахмал	
	Мидозолам	1 мг/мл/5 мл	флакон	
	Дроперидол	2,5 мг/мл-5 мл	флакон	
	фенабарбитал	5 мг, 100 мг	шахмал	
	Галоперидол	0,0015 мг	шахмал	
	Антикогулянт эмүүд	Гепарин	5000ЕД/1мг-5мл, 1мл	туншил
		Эноксапарин натри	4000IU/0.4мл	туншил
		Алтеплаза	50мг/мл	туншил
Ривароксабан		15мг, 20 мг	шахмал	
Варфарин		2,5 мг	шахмал	
Инсулин	Инсулин	100оун/мл - 3 , 10 мл	туншил	
	Метформин	500 мг	шахмал	
	Глимепирид	2 мг, 3 мг	шахмал	
Мэдрэл булчинд хориг үүсгэх	Суксаметоны хлорид	100мг/-2мл	туншил	
	Атракриум безалит	25мг/2.5мл	туншил	
	Пропофол	1%-20мл	туншил	
	Мэдээгүйжүүлэх эмүүд	Кетамин	5%-2мл	туншил
Изофлюран		200мл	туншил	
Бупивикайн		0.5%-2мл , 4 мл	туншил	
Прокайн		1%, 2%-100мл	Флакон	
Севофлуран		250мл	Флакон	
Тиофентал натрий		1г	туншил	
Хэм алдалтын эсрэг эм		Амиодарон	50мг/мл-3мл	туншил
	Дигоксин	0.025%-1мл	туншил	

	Лидокаин	2%-2мл	туншил
--	----------	--------	--------

Тайлбар: Өндөр эрсдэлт эмийн гадна савалгаанд “Улаан” өнгийн анхааруулах стикерээр ялган тэмдэглэнэ.

### ӨНДӨР КОНЦЕНТРАЦТАЙ ТАРИЛГЫН УУСМАЛ

Д/д	Эмийн нэрс	Тун хэмжээ	Хэмжих нэгж
1	Калийн хлорид	7.5%-100мл	Флакон
2	Калийн холимог шингэн	100мл, 250 мл	Флакон
3	Глюкоза	20% -500мл,250 мл	флакон
4	Натрийн хлорид	10%-500мл	Флакон
5	Магнийн сульфат	25%-10мл	туншил
6	Кальцийн глюконат	10%-10мл	туншил
7	Кальцийн хлорид	10%-10мл	туншил
8	Глюкоза	40%-10 мл	туншил

Тайлбар: Өндөр эрсдэлт эмийн гадна савалгаанд “Улаан” өнгийн анхааруулах стикерээр ялган тэмдэглэнэ.

### МАНСУУРУУЛАХ НӨЛӨӨТ ЭМИЙН ЖАГСААЛТ

Д/д	Эмийн нэрс	Тун хэмжээ	Хэмжих нэгж
1	Морфин	1%-1мл	туншил
2	Морфин	10мг	шахмал
3	Фентанил	0.005%-2мл	туншил
4	Трамадол гидрохлорид	100мг-2мл	туншил
5	Трамадол	50мг ,100 мг	шахмал
6	Ацетаминофен +код	1000/60мг	лаа
7	Ацетаминофен +код	500/30мг	шахмал



Тайлбар: Өндөр эрсдэлт эмийн ампул болон эмэнд Улаан өнгийн анхааруулах стикерээр ялган тэмдэглэнэ. Гадна савалгаа болон дусал шингэний савлагаанд наах:





Эмнэлгийн захирлын 2022 оны 11 дугаар сарын 20 -ны өдрийн 12 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ИЖИЛ ДУУДАГДДАГ ЭМИЙН ЖАГСААЛТ

1.	<b>ЭПИ</b> нефрин 1мг/1мл	<b>ЭФЕ</b> дрин 5%-1мл
2.	<b>КЕТО</b> профен 100мг	<b>КЕТО</b> тифен 1мг
3.	<b>ХЛОР</b> фенамин 4мг	<b>ХЛОР</b> амфеникол 500мг
4.	<b>ИМО</b> пек 2мг	<b>ИМО</b> пер
5.	<b>АПРОТОН</b> ин 10000ед/мл 10мл	<b>АТРОП</b> ин 0,1%-1мл
6.	<b>ЛАН</b> пурин 100мг	<b>ЛАН</b> сорбид 5мг
7.	<b>АМИО</b> дарон 200мг	<b>АМЛО</b> дипин 10мг
8.	<b>НИФ</b> едипин 20мг	<b>НИК</b> ардипин 25мг/10мл
9.	ана <b>ПРИЛИН</b> 40мг /пропорнолол/	Энала <b>ПРИЛ</b> 10мг
10.	<b>ОКТ</b> реотид 0,05м/мл	<b>ОНД</b> ансетрон 8мг/4мл
11.	<b>ОКТ</b> рео <b>ТИД</b> 0,05м/мл	Актра <b>ПИД</b> 40ед/1мл-10мл
12.	<b>АЦЕТА</b> минофен 500мг	<b>АЦЕТА</b> золамид 250мг
13.	<b>АЦЕТИЛ</b> салицилийн хүчил 75мг,100мг	<b>АЦЕТИЛ</b> цистейн 100мг,200мг,600мг
14.	Дро <b>ПЕРИ</b> дол 2.5мг/мл-5мл	Дом <b>ПЕРИ</b> дон 10мг
15.	<b>МЕТ</b> формин 500мг	<b>МЕТ</b> опролол 50мг





© 2005







**LOOK ALIKE/  
SOUND ALIKE**



## ИЖИЛ ХАРАГДДАГ ЭМИЙН ЖАГСААЛТ


Д/д	Эмийн нэрс	Тун хэмжээ	Ижил харагдах савалгаа
1	Кальци хлорид Кальци глюконат Магни сульфат	2,4%-10 мл 10%-10 мл 25%-10 мл	
2	Натри хлорид Натри хлорид Натри хлорид	0.9%-100 мл 0.9%-250 мл 0.9%-500 мл	
3	Кордамин Анальгин	0,025%-1 мл 50%-2 мл	
4	Кали хлорид Глюкоза	7,5%-100 мл 5%- 250мл, 100мл	

5	Натри хлорид Тарилгын нэрмэл ус	0,45%-500 мл 500 мл	
6	Цераксон Цераксон	1000 мг 500мг	
7	Флузол Флузол	100 мг 150 мг	
8	Лив-52 Цистон	Нийлмэл шахмал	

Тайлбар: Ижил харагддаг болон ижил дуудагддаг эмийн ампул савлагаанд **Улбар шар** өнгийн анхааруулах тэмдэгээр ялган тэмдэглэнэ.



Эмнэлгийн захирлын 2022 оны //  
сарын 28-ны өдрийн // дугаар  
тушаалын дөрөвдүгээр хавсралт



ӨНДӨР ЭРСДЭЛТ ЭМИЙН ГАРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ, АВАХ АРГА ХЭМЖЭЭ

	Эмийн бүлэг	Эмийн нэрс	Гарч эрсдэл болзошгүй	Алдаа гарахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа
1.	Адрено рецепторыг сэргээх эмүүд	Эпинефрин 1мг/1мл	<ul style="list-style-type: none"> <li>Хаягжилт дутмаг</li> <li>Тун, концентрацийн ялгааг андуурах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Захиалгын хэлбэрийг стандартжуулах</li> <li>Бүх савлагааг хаягжуулах</li> <li>Хэрэглэхээс өмнө эмийн тун пампын тохируулгыг дахин шалгах</li> <li>Өвчтөний зүрхний үйл ажиллагааг хянах</li> </ul>
2.	Инотроп эм	Допамин 200мг/мл ба добутамин 5мг/5мл	<ul style="list-style-type: none"> <li>Ижил дуудагдаж сонсогддог учраас андуурагдан хэрэглэгдэх магадлалтай</li> <li>Тарилгын хурдыг тооцоходоо алддаг</li> <li>Судасны гадуур тарих эрсдэлтэй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>DOBUT amine DOP amine гэж ялгааг тодотгон хаягжуулах</li> <li>Захиаллах тун ба тарих хурдыг тооцох тогтсон стандарттай байх</li> </ul>
		Дигоксин 0,025%-1мл	<ul style="list-style-type: none"> <li>Бусад үлгийн эмүүдтэй харилцан нөлөөлөхтэй,</li> <li>Тун хоорогдын зайг буруу тооцох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хэрэглээг хянах, үнэлэх протокол хөтлөх</li> <li>Тунг тооцож хэмжих, Ялангуяа настнуудад анхааралтай хэрэглэх.</li> </ul>
3.	Сэтгэц засах тайвшируулах эм	Диазепам 0,5%-2мл	<ul style="list-style-type: none"> <li>Тун хоорондын зайг зөв тооцох</li> <li>Тарилгын савалгааны тунг %ба мг/мл хэмжээгээр ялгаатай илэрхийлснээс гарах алдаа</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эмийн зөв зохистой хэрэглээг хянах</li> <li>Зөвхөн нэг тунгийн хэмжигдэхүүнээр илэрхийлэх</li> </ul>
4.	Антикоагулянт эмүүд	Гепарин 5000ЕД /1мл 5мл	Тунгийн алдаа, концентрацийн алдаа 1 флакон ба 1мл-т агуулагдах нэгж тунг андуурах	<ul style="list-style-type: none"> <li>Ижил харагдах, дуудагдах эмүүдээс холдуулах</li> <li>Анхааруулах тэмдэглэгээ тавих</li> <li>Давхар хяналтыг хийх</li> <li>Гепарин хэрэглээний үйлдлийг стандартчилах</li> <li>Нэгж тунгаар хэрэглэгдэх эмүүдээс холдуулах</li> <li>Тунг биеийн жинд үндэслэн тооцох</li> <li>Пампын тохируулгыг хянах</li> <li>Гепарин хольж шингэлсэн дусалд тэмдэг тавих</li> </ul>

5.	Цусны сахар бууруулах эм	Инсулин	<ul style="list-style-type: none"> <li>• Их тунгаар тарих</li> <li>• Пампын тохиргооноос шалтгаалсан алдаа Адилхан дуудагдах</li> <li>• эмүүдтэй андуурагдах /humulin/ Инсулин хийх заалтгүй буруу өвчтөнд тарих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• U-гэсэн тэмдэглэгээний оронд Unit гэж бүтэн бичиж хэвших</li> <li>• Нэгж тунг зөв тооцох Гепарин</li> <li>• ба инсулиныг тусад нь байрлуулах</li> <li>• Пампын тохиргоог давхар</li> <li>• шалгах</li> <li>• Тарих үйл явцыг</li> <li>• стандартчилах</li> <li>• Урт ба богино хугацааны</li> <li>• үйлдэлтэй инсулинуудыг ялгах</li> </ul>
6.	Эритролитийн тэнцвэрт нөлөөлөхэм /өндөр концентрацт ай тарилгын уусмал /	Калийн хлорид 7.5%100	<ul style="list-style-type: none"> <li>• Өндөр тунгаар хэрэглэх/зүрх зогсох эрсдэлтэй /</li> <li>• Тарилгын хурд буруу тооцох</li> <li>• Бусад тарилгын уусмалтай андуурагдах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Андуурагдахааргүй газарт зөв байрлуулах</li> <li>• Калийн хлорид хэрэглэх заалт</li> <li>• Дуслын хамгийн дээд хурд</li> <li>• Тарьж болох дээд концентраци</li> <li>• Зүрхний үйл ажиллагааг хянах удирдамж</li> <li>• Пампын тохиргоо</li> <li>• Калийн бэлдмэлийг тарьсны дараа санамсаргүйгээр дахин таригдах эрсдэлээс сэргийлэх</li> <li>• Судсанд тарихаас уух хэлбэрээр шилжүүлэн хэрэглэх боломж эсэхийг үнэлэх</li> </ul>
		Магнийн сульфат 25%	<ul style="list-style-type: none"> <li>• MSO4-MgSO4 /морфин сульфат ба магнийн сульфат/ товчлолыг андууран хэрэглэх mg,mEq,mL зэрэг олон хэмжигдэхүүнийг андуурах</li> <li>• Пампийн тохиргооны алдаа</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Протокол хөтлөх</li> <li>• Тунг тооцох талаар сургалт явуулах</li> <li>• Химийн нэршилээр бүү товчил</li> <li>• Тунг тооцох, пампын тохиргоог давхар шалгах тогтолцоо</li> <li>• Эмчилгээний тасагт их хэмжээгээр нөөцлөхгүй байх</li> <li>• /гарах эрсдэлээс сэргийлж/</li> </ul>

		Калийн глюкат 10%10мл Кальцийн хлори10%10мл	<ul style="list-style-type: none"> <li>• Кальцийн хэмжээг зөв тооцох</li> <li>• Судсанд тарих үед алдаа гаргаж булчинг гэмтээх</li> <li>• Дигоксин хэрэглэж байгаа өвчтөнд кальцийн бэлдмэлийг тарих хурднаас хамааран брадиаритм үүсгэнэ</li> <li>• Кальцийн сувагт хориг үүсгэх эмүүд болон даралт бууруулах эмүүдтэй антогностокидант үйлдэлтэй</li> <li>• .Гипокальциемитэй өвчтөнд кальцийн дутагдлын түвшинг хянах</li> <li>• Кальци хлоридын шалтгаантай эдийн үхжил үүсэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хэрэглээг хянах, үнэлэх протокол хөтлөх</li> <li>• Тунг тооцож стандартчил</li> <li>• Кальцийг зөвхөн миллиграммаар захиалах</li> </ul>
7.	Мансууруулах сэтгэц нөлөөт эмүүд	Морфин 1%-1мл Фентанил 0,005%-2мл Трамадол 2,5%-2мл	<p>Сувилагчийн тарилгын хэсэгт ил байснаас андуурагдах</p> <p>Эмийг таних, бэлтгэх, тарих явцад 1сувилагч гүйцэтгэснээс хамаарсан алдаа</p> <p>Өвдөлт намдаах хүчийг буруу тооцох тун, давтамж,хурдыг өвчтөнд тохируулаагүйгээс гарч буй алдаа</p> <p>Харшлын урвал илрэх Пампаас шалтгаалах алдаа</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Гарч болох эрсдэлийн талаар сургалт тогтмол хийх</li> <li>• Судсанд тарих эмийн концентрацийг стандартчилах</li> <li>• Нэг флаконд агуулагдаж буй эмийн онцентрацийг тооцох</li> <li>• Зөвхөн олон улсын нэршилээр нэрлэх</li> <li>• Тунг тооцох, пампын тохиргоог давхар шалгах тогтолцоо</li> <li>• Өвчтөнг харшилтай эсэхийг эсэхийг асууж хэвших</li> </ul>
8.	Мэдрэл булчинд хориг үүсгэдэг эмүүд	Суксаметон ы хлорид 100мг /2мл Векуроны бромид 10мг	<p>Хагалгааны өрөөнөөс бусад хэсэгт ил байрлуулсан тохилдолд андуурагдан тарих эрсдэл</p> <p>Адил харагдах вакцин бусад тарилгатай андуурагдах эрсдэл</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Бусад эмүүдээс ялгагдах тэмдэглэгээтэй байх Харагдах байрлалыг тодорхойлох</li> <li>• Шаардлагагүй тасгуудад байрлуулахгүй байх.</li> </ul>

Эмнэлгийн захирлын 2022 оны  
11 сарын 28-ны өдрийн 144 дугаар  
тушаалын тавдугаар хавсралт



### ӨНДӨР ЭРСДЭЛТ ЭМИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

№	Асуумж	
1.	Өндөр эрсдэлт эмийн тушаал, журмын тухай мэддэг байх	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
2.	Өндөр эрсдэлт эм хадгалж байгаа шүүгээнд хаягжилт хийсэн эсэх	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
3.	Өндөр эрсдэлт эм бүрт тусга тэмдэглэгээ наасан эсэх .	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
4.	Өндөр эрсдэлт эмийг бусад эмнээс тусад нь байршуулсан эсэх.	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
5.	Өндөр эрсдэлт эмийн зөөвөрлөх хайрцаг байгаа эсэх.	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
6.	Ижил харагддаг ижил дуудагддаг эмүүдийн жагсаалт байгаа эсэх	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
7.	Ижил харагддаг ижил дуудагддаг эмүүдэд тусгай тэмдэглэгээ зөв тавьсан эсэх.	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
8.	Судсаар хэрэглэж буй өндөр эрсдэлт эмийг шингэлсэн дуслын уут савалгаа дээр өндөр эрсдэлт эмийн тэмдэглэгээ нааж буй эсэх.	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
9.	Өндөр эрсдэлтэй эмийг хэрэглэх үед эмийн гаж нөлөө илэрсэн бол авах арга хэмжээ, журмыг мэддэг байх	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
10.	Өндөр эрсдэлт эмийн хэрэглээтэй холбоотой эмчилгээний алдаа, алдаанд ойрхон тохиолдол илэрсэн үед авах арга хэмжээг мэддэг байх.	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй

Тийм бол -1            үгүй бол - 0

Хянасан: Клиник эм зүйчийн гарын үсэг ...../ ..... /

Зөвшөөрсөн: Тасгийн эмч, сувилагч ...../...../